

БАНКУУДЫН ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ
(2023 оны III улирлын түүвэр судалгааны тайлан)

Судалгааны товч үр дүн

Банкуудаас 2023 оны 10 дугаар сарын 17-25-ны өдрийн хооронд санал асуулга хэлбэрээр өнгөрсөн болон ирэх 3 сарын хугацааны зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт, нийлүүлэлтийн талаарх мэдээллийг цуглуулан нэгтгэж, тайлан боловсруулав. Үр дүнг товч танилцуулбал:

Зээлийн шалгуур

- Өнгөрсөн 3 сарын хугацаанд том банкууд зээлийн шалгуураа бага зэрэг сулруулсан бол жижиг болон дунд банкууд зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулаагүй байна.
- Ирэх 3 сарын хугацаанд банкууд зээлийн шалгуураа хэвээр нь хадгалах хандлагатай байна.

Зээлийн нөхцөл

- Өнгөрсөн 3 сарын хугацаанд банкууд аж ахуйн нэгж, иргэдийн зээлийн нөхцөлдөө өөрчлөлт оруулаагүй байна.
- Ирэх 3 сарын хугацаанд том банкууд ААН-ийн зээлийн нөхцөлөө бага зэрэг чангаруулах төлөвтэй, харин бусад банкууд зээлийн нөхцөлөө хэвээр хадгалах хүлээлттэй байна.

Зээлийн эрэлт

- Өнгөрсөн 3 сарын хугацаанд том болон дунд банкуудын ААН-ийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгджээ. Харин жижиг банкуудын зээлийн эрэлтэд өөрчлөлт ороогүй байна.
- Ирэх 3 сард том болон дунд банкууд зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байгаа бол жижиг банкууд зээлийн эрэлт өөрчлөгдөхгүй гэж үзэж байна.

Зээлийн нийлүүлэлт

- Ирэх 3 сард том болон дунд банкууд зээлийн нийлүүлэлтээ бага зэрэг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Харин жижиг банкууд зээлийн нийлүүлэлтээ хэвээр хадгалах хандлагатай байна.

Хүснэгт 1.1 Судалгааны нэгдсэн үр дүн

Банкууд / Зээлийн төлөв	Зээлийн шалгуур		Зээлийн нөхцөл		Зээлийн эрэлт		Зээлийн нийлүүлэлт	
	ААН	Иргэд	ААН	Иргэд	ААН	Иргэд	ААН	Иргэд
Өнгөрсөн 3 сарын хугацаанд								
Том	↓	↓	0	0	↑	0		
Дунд	0	0	0	0	↑	0		
Жижиг	0	0	0	0	0	0		
Ирэх 3 сарын хугацаанд								
Том	0	0	↑	0	↑	↑	↑	↑
Дунд	0	0	0	0	↑	0	0	↑
Жижиг	0	0	0	0	0	0	0	0

Тэмдэглэл: ↑ бага зэрэг чангарах/нэмэгдэх; ↑↑ нэлээд чангарах/нэмэгдэх; 0 өөрчлөгдөөгүй; ↓ бага зэрэг сулрах/буурах; ↓↓ нэлээд сулрах/буурах

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь банкуудаас олгож буй зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт болон нийлүүлэлт, тэдгээрийн цаашдын төлөвийг тодорхойлоход оршино.

Судалгааны хамрах хүрээ

Банкны зээлийн төлөвийн судалгаанд нийт 12 банкыг хамруулсан бөгөөд тухайн банкны зээлийн үйл ажиллагаа хариуцсан шийдвэр гаргах түвшний удирдах албан тушаалтнуудаас асуулга авсан болно.

Арга зүйн товч тайлбар

Банкны зээлийн төлөвийн судалгаа нь санал асуулга хэлбэрээр зохион байгуулагддаг бөгөөд (i) зээлийн шалгуур, (ii) зээлийн нөхцөл, (iii) зээлийн эрэлт болон (iv) зээлийн нийлүүлэлт гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрдэнэ. Судалгааны үр дүнг нэгтгэхдээ банкуудын чанарын хариултуудыг нэг утгатайгаар тодорхойлохын тулд тоон утга руу хөрвүүлсэн. Ингэхдээ [-1;+1] хоорондох утгуудад чанарын асуултуудыг Хүснэгт 1.2-т өгөгдсөн байдлаар индексэд хөрвүүлдэг.

Хүснэгт 1.2 Индексийн тооцоолол					
Индексийн утга	-1.0	-0.5	0	0.5	1.0
Зээлийн шалгуур	Нэлээд суларсан/суларна	Бага зэрэг суларсан/суларна	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг чангарсан/чангарна	Нэлээд чангарсан/чангарна
Зээлийн нөхцөл	Нэлээд суларсан/суларна	Бага зэрэг суларсан/суларна	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг чангарсан/чангарна	Нэлээд чангарсан/чангарна
Зээлийн эрэлт	Нэлээд багассан/багасна	Бага зэрэг багассан/багасна	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг нэмэгдсэн/нэмэгдэнэ	Нэлээд нэмэгдсэн/нэмэгдэнэ
Зээлийн нийлүүлэлт	Нэлээд бууруулна	Бага зэрэг бууруулна	Өөрчлөгдөхгүй	Бага зэрэг нэмэгдүүлнэ	Нэлээд нэмэгдүүлнэ


Нийт системийн зээлийн төлөвийг тодорхойлохдоо банк тус бүрийн зээлийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээг тухайн банкны харгалзах индексээр үржүүлэх замаар жигнэсэн дундаж утгыг тооцсон болно. Тухайн хугацаан дахь ерөнхий индексийн утга нь зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт, нийлүүлэлтийн талаарх өнгөрсөн 3 сарын байдал болон ирэх 3 сарын төлөвийг илэрхийлнэ.

I. Зээлийн шалгуур

1.1 Аж ахуйн нэгжийн зээлийн шалгуур

- Банкуудын ААН-ийн зээлийн шалгуур 2018 оноос хойш харьцангуй тогтвортой байсан бол 2021 оны I улирлаас эхлэн 4 улирлын турш сулрах мужид байжээ. Харин банкууд 2022 оны I улирлаас эхлэн зээлийн шалгуураа чангаруулж эхэлсэн бол сүүлийн 3 улиралд сулруулаад байна. 2023 оны III улиралд ААН-ийн зээлийн шалгуурын индекс -0.13 гарсан бөгөөд зээлийн шалгуур бага зэрэг суларсан байна. Ирэх улиралд банкууд ААН-ийн зээлийн шалгуураа хэвээр хадгалах төлөвтэй байна (Зураг 1).

Зураг 1. ААН-ийн зээлийн шалгуур ба хүлээлт




- Банкууд 2023 оны III улиралд худалдаа, үйлчилгээний салбарт олгох зээлийн шалгуурыг бага зэрэг сулруулсан бол ХАА, уул уурхай, боловсруулах үйлдвэр, барилгын салбарын зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулаагүй байна. 2023 оны IV улиралд бүх салбаруудын зээлийн шалгуураа хэвээр нь хадгалах хандлагатай байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. ААН-ийн зээлийн шалгуур, салбараар

Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2023.III улирлын хүлээлт	0	0	0	0	0	0
2023.III улирлын үр дүн	-0.13	0	0	0	0	-0.12
2023.IV улирлын хүлээлт	0	0	0	0	0	0

- 2023 оны III улиралд ААН-ийн зээлийн шалгуурыг сулруулахад банкны эрсдэл даах чадвар сайжирсан нь гол нөлөөг үзүүлжээ (Зураг 2).


Зураг 2. ААН-ийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс



1.2 Иргэдийн зээлийн шалгуур

- Банкуудын иргэдийн зээлийн шалгуур 2020 оноос хойш харьцангуй тогтвортой байсан бол 2022 оны I улирлаас эхлэн 4 улирлын турш чангаруулсан байна. Харин 2023 оны I улирлаас эхлэн нэлээд сулруулж байсан байна. 2023 оны III улиралд иргэдийн зээлийн шалгуурын индекс -0.25 гарсан бөгөөд банкууд зээлийн шалгуураа бага зэрэг сулруулжээ. Ирэх улиралд банкууд иргэдийн зээлийн шалгуураа хэвээр нь хадгалах хандлагатай байна (Зураг 3).

Зураг 3. Иргэдийн зээлийн шалгуур ба хүлээлт




- Банкууд 2023 оны III улиралд цалингийн, бизнесийн, малчны болон автомашины зээлийн шалгуураа бага зэрэг сулруулсан бол тэтгэврийн, хэрэглээний зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулаагүй байна. Ирэх улиралд цалингийн, малчны болон автомашины зээлийн шалгуураа бага зэрэг сулруулж, бусад төрлийн зээлийн шалгуураа хэвээр хадгалах төлөвтэй байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Иргэдийн зээлийн шалгуур, зээлийн ангиллаар

Хугацаа	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашины зээл
2023.III улирлын хүлээлт	0	0	0	-0.25	0	0	-0.10
2023.III улирлын үр дүн	-0.25	-0.17	0	0	-0.36	-0.25	-0.11
2023.IV улирлын хүлээлт	0	-0.28	0	0	0	-0.25	-0.14

- 2023 оны III улиралд иргэдийн зээлийн шалгуурыг сулруулахад нөлөөлсөн хүчин зүйлсийг авч үзвэл өрсөлдөөн, эдийн засгийн нөхцөл байдал голлон нөлөөлжээ (Зураг 4).

Зураг 4. Иргэдийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс




II. Зээлийн нөхцөл

2.1 Аж ахуйн нэгжийн зээлийн нөхцөл

- Банкуудын ААН-ийн зээлийн нөхцөл 2018 оноос хойш харьцангуй тогтвортой байсан бол 2021 оны I улирлаас эхлэн огцом суларч, чиглэлийн индексийн утга нь 5 улирлын турш сулрах мужид байжээ. Харин 2022 оны II улирлаас эхлэн чангарч эхэлсэн бол энэ оны эхнээс бага зэрэг суларсан байна. 2023 оны III улиралд банкууд ААН-ийн зээлийн нөхцөлөө бага зэрэг чангаруулсан бөгөөд ирэх улиралд мөн адил бага зэрэг чангаруулах төлөвтэй байна (Зураг 5).

Зураг 5. ААН-ийн зээлийн ерөнхий нөхцөл ба хүлээлт




- Банкууд 2023 оны III улиралд ХАА, уул уурхай, боловсруулах үйлдвэр болон барилгын салбарт олгох зээлийн нөхцөлөө бага зэрэг чангаруулсан бол худалдаа, үйлчилгээний салбарт олгох зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулсан байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. ААН-ийн зээлийн ерөнхий нөхцөл, салбараар

Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2023.II улирлын үр дүн	-0.02	-0.09	0.07	-0.02	0.04	-0.05
2023.III улирлын үр дүн	0.04	0.02	0.06	0.03	0.04	-0.01

- 2023 оны III улиралд банкууд ААН-ийн зээлийн хүүг өсгөх болон зээлдэгчийн гэрээгээр хүлээх үүргийг нэмэгдүүлэх зэргээр зээлийн нөхцөлөө чангаруулсан бол барьцаа хөрөнгийн шаардлагыг бууруулан нөхцөлөө сулруулжээ (Зураг 6).

Зураг 6. ААН-ийн зээлийн нөхцөлүүд




- Хүснэгт 4-т банкуудаас ААН-д тухайн улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХүү) болон жигнэсэн дундаж хугацаа (ЖДХугацаа)-г түүвэр судалгааны үр дүнд гарсан зээлийн хүү ба хугацааны индекстэй харьцуулан эдийн засгийн салбаруудаар харуулав. 2023 оны III улиралд барилгын салбарт олгосон зээлийн ЖДХүү өмнөх улирлаас өссөн бөгөөд энэ нь түүвэр судалгааны үр дүнтэй нийцтэй гарсан байна. Харин бусад салбарын хувьд эсрэг үр дүн гарчээ. Нийт салбаруудад олгосон зээлийн ЖДХугацаа буурсан бол түүвэр судалгаагаар банкууд дийлэнх салбаруудад олгосон зээлийн хугацаанд өөрчлөлт оруулаагүй гэж хариулсан байна.

Хүснэгт 4. ААН-д олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү болон хугацаа, салбараар						
Зээлийн нөхцөлүүд	Хугацаа	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
Банкуудын зээлийн ЖДХүү (хувь)	- 2023.II улирал	9.4	15.6	16.2	16.9	18.0
	- 2023.III улирал	14.3	13.8	13.9	17.1	15.9
	- Өөрчлөлт	<u>+4.9</u>	<u>-1.8</u>	<u>-2.3</u>	<u>+0.2</u>	<u>-2.1</u>
Зээлийн хүү (судалгааны үр дүн)	2023.III улирал	0	0.21	0.14	0.13	0.18
Банкуудын зээлийн ЖДХугацаа (сар)	- 2023.II улирал	39.1	17.9	41.6	35.4	42.7
	- 2023.III улирал	30.9	9.3	38.1	32.7	37.1
	- Өөрчлөлт	<u>-8.2</u>	<u>-8.6</u>	<u>-3.5</u>	<u>-2.7</u>	<u>-5.6</u>
Зээлийн хугацаа (судалгааны үр дүн)	2023.III улирал	0	0.04	0	0	0

2.2 Иргэдийн зээлийн нөхцөл

- Банкууд иргэдийн зээлийн нөхцөлөө 2021 оны I улирлаас эхлэн сулруулж байсан бол 2022 оны II улирлаас эхлэн чангаруулсан байна. Харин энэ оны эхнээс банкууд зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулжээ. Ирэх улиралд банкууд иргэдийн зээлийн нөхцөлөө бага зэрэг чангаруулах төлөвтэй байна (Зураг 7).

Зураг 7. Иргэдийн зээлийн ерөнхий нөхцөл ба хүлээлт




- Банкууд 2023 оны II улиралд тэтгэврийн зээлээс бусад төрлийн зээлийн нөхцөлийг бага зэрэг сулруулсан бол 2023 оны III улиралд тэтгэврийн зээл, автомашины зээлээс бусад төрлийн зээлийн нөхцөлөө мөн бага зэрэг сулруулсан хэвээр байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Иргэдийн зээлийн ерөнхий нөхцөл, зээлийн төрлөөр

Хугацаа	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашинны зээл
2023.II улирлын үр дүн	-0.06	-0.09	0.04	-0.12	-0.25	-0.20	-0.26
2023.III улирлын үр дүн	0	-0.06	0.04	-0.06	-0.04	-0.1	0

- 2023 оны III улиралд банкууд иргэдэд олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлсэн бол зээлийн хугацааг богиносгожээ. Харин зээлийн бусад нөхцөлд өөрчлөлт оруулаагүй байна (Зураг 8).

Зураг 8. Иргэдийн зээлийн нөхцөлүүд



- Хүснэгт 6-д банкуудаас иргэдэд тухайн улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХүү) болон жигнэсэн дундаж хугацаа (ЖДХугацаа)-г түүвэр судалгааны үр дүнд гарсан зээлийн хүү ба хугацааны индекс тэй харьцуулан зээлийн төрлөөр харуулав. 2023 оны III улиралд бүх төрлийн зээлийн ЖДХүү өмнөх улирлаас төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд энэ нь түүвэр судалгааны үр дүнтэй ерөнхийдөө нийцтэй байна. Цалингийн болон автомашины зээлээс бусад төрлийн зээлийн ЖДХугацаа 1.4-3.7 сараар буурсан бол түүвэр судалгаагаар тэтгэврийн зээлээс бусад зээлүүдийн хугацааг хэвэндээ байсан гэж хариулжээ.

Хүснэгт 6. Иргэдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү болон хугацаа, салбараар


Зээлийн нөхцөлүүд	Хугацаа	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Малчны зээл	Автомашинны зээл
Банкуудын зээлийн ЖДХүү (хувь)	- 2023.II улирал	17.4	16.1	22.1	20.0	19.3
	- 2023.III улирал	17.4	15.9	21.5	20.8	20.7
	- Өөрчлөлт	<u>0</u>	<u>-0.2</u>	<u>-0.6</u>	<u>+0.8</u>	<u>+1.4</u>
Зээлийн хүү (судалгааны үр дүн)	2023.III улирал	-0.07	0	-0.15	0	0.02
Банкуудын зээлийн ЖДХугацаа (сар)	- 2023.II улирал	28.8	14.4	32.3	27.1	29.3
	- 2023.III улирал	29.3	11.9	30.9	23.4	30.1
	- Өөрчлөлт	<u>+0.5</u>	<u>-2.5</u>	<u>-1.4</u>	<u>-3.7</u>	<u>+0.8</u>
Зээлийн хугацаа (судалгааны үр дүн)	2023.III улирал	0	0.09	0	0	0

Ш. Зээлийн эрэлт

3.1 Аж ахуйн нэгжийн зээлийн эрэлт

- ААН-ийн зээлийн эрэлт 2020 оны I, II улирлыг эс тооцвол 2018 оноос өнөөг хүртэл өндөр хэвээр байна. 2023 оны III улиралд ААН-ийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдсэн нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарчээ. Ирэх улиралд ААН-ийн зээлийн эрэлт мөн нэмэгдэх төлөвтэй байна (Зураг 9).

Зураг 9. ААН-ийн зээлийн эрэлт ба хүлээлт




- 2023 оны III улиралд ихэнх салбаруудын зээлийн эрэлт өссөн нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан байна. Ялангуяа, ХАА болон худалдаа, үйлчилгээний салбарын зээлийн эрэлт бусад салбаруудтай харьцуулахад өндөр байжээ. 2023 оны IV улиралд уул уурхай, боловсруулах үйлдвэр, худалдаа үйлчилгээний салбаруудын зээлийн эрэлт нэмэгдэх төлөвтэй байна. Ялангуяа, худалдаа, үйлчилгээний салбарт зээлийн эрэлт нэлээд нэмэгдэх хүлээлттэй байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. ААН-ийн зээлийн эрэлт, салбараар

Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2023.III улирлын хүлээлт	0.45	0.41	0.16	0.23	0.32	0.45
2023.III улирлын үр дүн	0.40	0.30	0.05	0.22	0.21	0.53
2023.IV улирлын хүлээлт	0.47	0	0.08	0.23	0	0.66

- 2023 оны III улиралд ААН-ийн зээлийн эрэлт нэмэгдэхэд эргэлтийн хөрөнгө болон үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтын зээлийн хүсэлт өссөн нь голлон нөлөөлжээ (Зураг 10).


Зураг 10. ААН-ийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс



3.2 Иргэдийн зээлийн эрэлт

- Иргэдийн зээлийн эрэлт 2018 оноос хойш нэлээд хэлбэлзэлтэй байсан бол 2021 оны III улирлаас өнөөг хүртэл өндөр хэвээр байна. 2023 оны III улиралд иргэдийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдсэн нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан бөгөөд ирэх улиралд мөн нэмэгдэх хүлээлттэй байна (Зураг 11).

Зураг 11. Иргэдийн зээлийн эрэлт ба хүлээлт




- 2023 оны III улиралд тэтгэврийн, хэрэглээний, бизнесийн зээлийн эрэлт нэмэгдсэн бөгөөд энэ нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан байна. Харин цалингийн, малчны, автомашины зээлийн эрэлт хэвэндээ гарчээ. 2023 оны IV улиралд бүх төрлийн зээлийн эрэлт нэмэгдэх хүлээлттэй байна. Ялангуяа, цалингийн, тэтгэврийн, малчны, автомашины зээлийн эрэлт нэлээд нэмэгдэх хүлээлттэй байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Иргэдийн зээлийн эрэлт, зээлийн төрлөөр

Хугацаа	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашины зээл
2023.III улирлын хүлээлт	0.47	0.43	0.52	0.64	0.41	0.26	0.50
2023.III улирлын үр дүн	0.15	0	0.15	0.10	0.10	0	0
2023.IV улирлын хүлээлт	0.39	0.55	0.53	0.47	0.37	0.50	0.56

- 2023 оны III улиралд иргэдийн зээлийн эрэлт нэмэгдэхэд зээлийн хүүний ерөнхий түвшин, удаан эдэлгээт барааны худалдан авалт, эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэрэглэгчдийн итгэл нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлжээ (Зураг 12).

Зураг 12. Иргэдийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс




IV. Зээлийн нийлүүлэлт

4.1 Аж ахуйн нэгжийн зээлийн нийлүүлэлт

- Банкууд ААН-ийн зээлийн нийлүүлэлтээ 2021 оноос өнөөг хүртэл нэмэгдүүлэх хандлагатай хэвээр байна. 2023 оны III улиралд ААН-д 4.65 их наяд төгрөгийн зээл шинээр олгосон нь өмнөх улирлаас 1.0%-аар өссөн үзүүлэлт байлаа. 2023 оны IV улиралд банкууд ААН-д олгох зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлэх төлөвтэй байна (Зураг 13).

Зураг 13. ААН-ийн зээлийн нийлүүлэлтийн төлөв ба шинээр олгосон зээл



- Банкууд 2023 оны IV улиралд бүх салбарт олгох зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлэх төлөвтэй байна. Ялангуяа худалдаа, үйлчилгээний салбарт олгох зээлийн нийлүүлэлтээ бусад салбаруудаас илүүтэй нэмэгдүүлэх хандлагатай байна (Хүснэгт 9).


Хүснэгт 9. ААН-ийн зээлийн нийлүүлэлт, салбараар

Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2023.III улирлын хүлээлт	0.43	0.41	0.20	0.23	0.29	0.43
2023.IV улирлын хүлээлт	0.44	0.29	0.13	0.24	0.22	0.64

4.2 Иргэдийн зээлийн нийлүүлэлт

- Банкууд иргэдийн зээлийн нийлүүлэлтээ 2022 оны III улирлыг эс тооцвол 2021 оноос өнөөг хүртэл нэмэгдүүлэх хандлагатай хэвээр байна. Харин 2023 оны III улиралд иргэдэд 4.94 их наяд төгрөгийн зээл шинээр олгосон нь өмнөх улирлаас 11.7%-аар буурчээ. 2023 оны IV улиралд банкууд иргэдэд олгох зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлэх төлөвтэй байна (Зураг 14).

Зураг 14. Иргэдийн зээлийн нийлүүлэлтийн төлөв ба шинээр олгосон зээл



*- Ипотекийн зээлийг эс тооцов.

- Банкууд 2023 оны IV улиралд бүх төрлийн зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлэх хүлээлттэй байна. Ялангуяа, хэрэглээний, автомашины зээлийн нийлүүлэлтээ нэлээд нэмэгдүүлэх хандлагатай байна (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Иргэдийн зээлийн нийлүүлэлт, зээлийн төрлөөр							
Хугацаа	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашины зээл
2023.III улирлын хүлээлт	0.47	0.54	0.52	0.72	0.41	0.26	0.52
2023.IV улирлын хүлээлт	0.45	0.50	0.43	0.57	0.38	0.50	0.58

Хавсралт 1. ААН болон иргэдийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс

Хүснэгт 11. ААН-ийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс, салбараар (2023.III улирал)						
Хүчин зүйлс	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
Эх үүсвэрийн зардал, боломж						
Эх үүсвэрийн өртөг	0.09	0.06	0.21	0.13	0.12	0.11
Санхүүжилтийн боломж	0.05	0.02	0	0	0	0
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	-0.13	-0.25	0	0	0	0
Өрсөлдөөн						
Бусад банкуудын өрсөлдөөн	0	0.02	0	0	0	0
Бусад санхүүгийн байгууллагын өрсөлдөөн	0.01	0	0	0	0	0
Санхүүгийн захын өрсөлдөөн	0.01	0	0	0	0	0
Эдийн засгийн байдал						
Эдийн засгийн өсөлт	0.13	0.05	0.17	0.13	0.12	0.11
Инфляци	0.01	0	0	0	0	0
Валютын ханш	0	0	0	0	0	0
Эрсдэл						
Тухайн салбарын төлөв байдал	-0.13	0.02	0	0	0	-0.18
Барьцаа хөрөнгийн эрсдэл	0	0	0	0	0	0
Банкны эрсдэл даах чадвар	-0.13	0.02	0	0	0	-0.17

Хүснэгт 12. Иргэдийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс, зээлийн төрлөөр (2023.III улирал)							
Хүчин зүйлс	Нийт зээл	Цалин-гийн зээл	Тэтгэв-рийн зээл	Хэрэглээ-ний зээл	Бизнес-ийн зээл	Малчны зээл	Автомашин-ны зээл
Эх үүсвэрийн зардал, боломж							
Эх үүсвэрийн өртөг	0	-0.04	0	0	0	0	-0.11
Санхүүжилтийн боломж	0	-0.04	0	0	0	0	-0.11
Өрсөлдөөн							
Бусад банкны өрсөлдөөн	-0.24	-0.33	0	0	0	-0.25	-0.11
Бусад санхүүгийн байгууллагын өрсөлдөөн	0	-0.04	0	0	0	0	-0.11
Эдийн засгийн байдал							
Эдийн засгийн өсөлт	0	0.01	0	0	0	0	0
Инфляци	0.01	0.03	0	0	0	0	0
Валютын ханш	0	0	0	0	0	0	0
Эрсдэл							
Төлбөрийн чадвар	-0.24	-0.05	0	0	-0.27	-0.25	-0.11
Барьцаа хөрөнгийн эрсдэл	0	0	0	0	0	0	0
Банкны эрсдэл даах чадвар	0	-0.05	0	0	-0.27	-0.25	-0.11

Хавсралт 2. ААН болон иргэдийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс

Хүснэгт 13. ААН-ийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс, салбараар (2023.III улирал)						
Хүчин зүйлс	Нийт зээл	ХАА	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
Санхүүжилтийн хэрэгцээ						
Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт	0.40	0.40	0.10	0.23	0.26	0.40
Эргэлтийн хөрөнгө	0.45	0.69	0.10	0.23	0.26	0.64
Ажиллах хүчин болон тоног төхөөрөмж	0.25	0.32	0.08	0	0	0.06
Компанийн нэгдэл, бүтцийн өөрчлөлт	0	0	0	0	0	0
Зээлийн хүүний ерөнхий түвшин	0	0	0	0	0	0
Өрийн дахин санхүүжилт	0	0	0	0	0	0.06
Бусад санхүүжилтийн хэлбэрүүд						
Дотоод санхүүжилт	0.20	0.32	0.09	0.16	0.20	0.19
Бусад банкуудаас зээлэх	0.18	0.27	0.05	0.14	0.17	0.17
Бусад санхүүгийн байгууллагаас зээлэх	0	0	0	0	0	0
Үнэт цаас, хувьцаа гаргах	0	0	0	0	0	0
Гадаад зах зээлээс санхүүжилт татах	0	0	0	0	0	0

Хүснэгт 14. Иргэдийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс, зээлийн төрлөөр (2023.III улирал)							
Хүчин зүйлс	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашинны зээл
Санхүүжилтийн хэрэгцээ							
Удаан эдэлгээтэй бараа худалдан авалт	0.25	0.29	0.03	0.21	0	0	0.33
Хэрэглэгчдийн итгэл	0.25	0.36	0.39	0.21	0.28	0.25	0.33
Зээлийн хүүний ерөнхий түвшин	0.31	0.28	0.38	0.19	0.27	0.50	0.32
Өрийн дахин санхүүжилт	0	0.05	0.03	0.09	0	0	0.11
Үнэт цаас худалдан авалт	0	0	0	0	0	0	0
Бусад санхүүжилтийн хэлбэрүүд							
Өрхийн хуримтлал	0	0.14	0.03	0.09	0	0	0.11
Бусад банкуудаас зээлэх	0.24	0.29	0.38	0.21	0.27	0.25	0.32
Санхүүжилтийн бусад эх үүсвэр	0	0.06	0.03	0.09	0	0	0.11